

2026 он 2 сар 19 өдөр

№ 26/03

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм, Ногдол ашгийн журам болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн тухай хуулийн 47.1 дэх заалт болон Компанийн Ногдол ашгийн журмын 2.1-г заасныг тус тус үндэслэн компанийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны санхүүгийн жилд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар **ШИЙДВЭРЛЭСҮГЭЙ**.
2. Компани нь хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Уянгад **ДААЛГАСУГАЙ**.
3. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн талаарх мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Энхзулд **ДААЛГАСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ